

Зүрхний ажиллах зарчмыг бүдүүвчээр илэрхийлэх хичээлийн бататгал дасгал


1. Зүрхний мөчлөгийн эхлэл, хяналт зохицуулгатай холбоотой үйл явцыг хүснэгтэд жагсаасан. Үйл явцыг зөв дараалалд оруулахын тулд хүснэгтийн багана хэсэгт тохирох тоог нөхнө үү.

Үйл явц	Дараалал
Пуркинье ширхгээр импульс дамжих	
Тосгуур ховдлын зангилаанаас импульс тархах	
Тосгуур агших	
Ховдол агших	
Синусын зангилаанаас импульс тархах	


2. Хэвийн зүрхний цахилгаан бичлэг (ЗЦБ) нь зүрхний цикл тус бүрийн үед зүрхний янз бүрийн хэсгүүдийн цахилгаан идэвхжлийг илэрхийлдэг хэд хэдэн өөр шүдлэгүүдээс бүрддэг.

Эдгээр шүдлэгүүдийг латин цагаан толгойн үсгийн дарааллаар P шүдлэгээр эхэлж цаашид QRS бүрдэл, төгсгөлд нь ST-T-U бүрдэл (ST сегмент, T шүдлэг, болон U шүдлэг) гэж тэмдэглэдэг. QRS бүрдлийн төгсгөл болон ST сегментийн эхлэл хоорондох холбоосыг J цэг гэдэг.

Дээрх тайлбар, графикийг судлаад, дараах нөхцөлүүд Үнэн эсвэл Худал эсэхийг тодорхойл.



- QT интервал нь ховдлын реполяризацийг харуулж байна.
 - QRS интервал нь ховдлын деполяризацийн хугацааг илэрхийлж байна.
 - P шүд нь тосгуурын деполяризацийг илтгэнэ.
 - Тосгуур ховдлын зангилааны дамжуулалт буурснаар PR интервал богиносно.
3. Зургийг тайлбартай зөв тохируулаарай.



Зүрхний
хэвийн цохилт

Зүрхний
хурдан цохилт

Зүрхний
удаан цохилт

Зүрхний хэвийн
бус цохилт

